

Төрийн нарийн бичгийн даргын
2022 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн
57-дүгээр тушаалын 8- дугаар хавсралт
24



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Засгийн газрын 2021 оны 265 дугаар тогтоол, 2022 оны 23 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Боловсрол, шинжлэх ухаан яам

Нэгжийн нэр:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

Албан тушаалын нэр:

Ерөнхий болон дээд боловсрол, харьяа байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ, нэгдсэн тайлагналт хариуцсан ахлах шинжээч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-10

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Ерөнхий болон дээд боловсролын салбарын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл, төлөвлөгөө, үндсэн чиглэл, хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, хөтөлбөрийн хэрэгжилт, харьяа байгууллага, яамны дотоод нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх үйл ажиллагааг зохион байгуулах, газрын төлөвлөгөө, тайлан, дотоод бусад чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Төрийн албаны зөвлөлийн
2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн
168 дугаар тогтоолын 16 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Засгийн газрын 2021 оны 265 дугаар тогтоол, 2022 оны 23 дугаар тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Боловсрол, шинжлэх ухаан яам

Нэгжийн нэр:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

Албан тушаалын нэр:

Ерөнхий болон дээд боловсрол, харьяа байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ, нэгдсэн тайлагналт хариуцсан ахлах шинжээч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, Т3-10

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 44, Засгийн газрын III байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Ерөнхий болон дээд боловсролын салбарын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл, төлөвлөгөө, үндсэн чиглэл, хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, хөтөлбөрийн хэрэгжилт, харьяа байгууллага, яамны дотоод нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх үйл ажиллагааг зохион байгуулах, газрын төлөвлөгөө, тайлан, дотоод бусад чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Ерөнхий болон дээд боловсролын салбарын хэмжээнд хэрэгжих бодлогын баримт бичиг, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр, дүрэм журам, хөтөлбөр, тайлангийн хэрэгжилтийн явц үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, уялдааг хангах;
- 2.Ерөнхий болон дээд боловсролын байгууллагууд, харьяа байгууллага, яамны дотоод нэгжүүдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлж дүгнэх, биелэлтэд хяналт тавих, мэдээлэлтэй танилцах үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 3.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Ерөнхий болон дээд боловсролын салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, холбогдох талуудыг мэдээллээр хангах, зөвлөмжийн биелэлтийг хангуулан хяналт тавьж ажиллах;	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажилласан байна.	Т, Г, Х
	2.Ерөнхий болон дээд боловсролын салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт өгөх, холбогдох талуудыг мэдээллээр хангах;	Салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн тайланг удирдлагад танилцуулсан байна.	Т, Г, Х
	3.Салбарын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, нэмэлт, өөрчлөлт оруулах, санал, зөвлөмж боловсруулах;	Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийн саналыг оруулсан байна.	Г, Х, Т
	4.Ерөнхий болон дээд боловсролын салбарын үйл ажиллагааны тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг олон улсын түвшний үзүүлэлттэй харьцуулан шинжилгээ хийх;	Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг олон улсын жишиг түвшний үзүүлэлттэй харьцуулсан байна.	Т, Г, Х
	5.Салбарын хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр тулгамдаж буй асуудлыг олон улсын чиг хандлагад нийцүүлэн	Шинжилгээ хийсэн тайлан, дүгнэлт саналыг холбогдох удирдах ажилтан, нэгж,	Х, Г, Ш



	судалж, үндэслэл бүхий санал, арга хэлбэр, шийдлийн хувилбарыг боловсруулах, хэлэлцүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг удирдлагаар хангах;	албан хаагчдад цаг тухайд нь танилцуулсан байна.	
	6.Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээрх эрхзүйн баримт бичгийн төслийг боловсруулах, дүн шинжилгээ хийх, дүгнэлт, санал гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд танилцуулах;	Эрх зүйн баримт бичгийг цаг тухайд нь боловсруулж, баталгаажуулсан байна	Х, Г
	7.Хяналт-шинжилгээ, үнэлгээний бүтэц, тогтолцоог олон улсын жишгийг баримжаалан хөгжүүлэх чиглэл боловсруулах ажлыг холбогдох нэгж, мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулах;	Чиглэлийг цаг тухайд нь боловсруулсан байна.	Х, Г
	8.Салбарын бодлого, эрхзүйн баримт бичиг, салбарын төсөв, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг арга зүйн удирдлагаар хангах;	Шинжилгээний тайланг гарах ажлыг зохион байгуулсан байна.	Х, Г
	9.Салбарын хөгжлийн /урт, дунд хугацааны/ бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нэгтгэх ажлыг зохион байгуулах;	Салбарын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн төлөвлөгөө боловсруулж, яамны нэгж, холбогдох талуудад танилцуулсан тайлагнасан байна.	Х, Г
	10.Удирдлага, эрх бүхий байгууллагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний талаар нэгдсэн мэдээ, мэдээлэл, тайланг бэлтгэн танилцуулах;	Үнэн зөв, бүрэн мэдээллээр шуурхай хангасан байна.	Х, Г
	11.Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн нэгдсэн сан үүсгэх.	Тайлангийн нэгдсэн сан үүсгэж, тайланг нэгдсэн санд оруулсан байна.	Г, Х, Т
	1.Ерөнхий болон дээд боловсрол, харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах;	Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, оновчтой, зөв шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлсэн байна.	Г, Х, Т
	2. Ерөнхий болон дээд боловсрол, харьяа байгууллагуудын засаглал, эрсдэлийн удирдлагад чиглэсэн зөвлөмж, мэдээлэл өгч дэмжлэг үзүүлэх;	Хяналт-шинжилгээний зөвлөмж мэдээллийг хүргэж ажилласан байна.	Г, Х, Т



2 дугаар зорилтын хүрээнд	3.Ерөнхий болон дээд боловсролын салбарын бодлого хэрэгжилтийг зохион байгуулж буй яамны дотоод нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх;	Хяналт-шинжилгээний зөвлөмж мэдээллийг хүргэж ажилласан байна.	Г, Х, Т
	4.Ерөнхий болон дээд боловсролын салбарт хэрэгжүүлэхээр баталсан Сайдын тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллах, удирдлагыг мэдээллээр хангах;	Сайдын тушаалын биелэлтэд хяналт тавьж ажилласан байна.	Г, Х, Т
	5.Ерөнхий болон дээд боловсролын чиглэлээр Үндэсний аудитын газар бусад байгууллагаас хийгдсэн хяналт шалгалтын хүрээнд илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллах;	Шаардлагатай зөвлөмжийг хүргүүлж, биелэлтийг хангуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан байна.	Г, Х, Т
	6.Салбарын хэмжээнд мөрдөх хяналт-шинжилгээ, үнэлгээний стандарт, норм, нормативыг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд дүн шинжилгээ хийх, стратегийн зорилго, зорилтод нийцэж буй эсэх, салбар хоорондын уялдааг хангах талаар дүгнэлт, санал гаргах, боловсруулах, хэлэлцүүлэхэд бусад газартай хамтарч ажиллах;	Эрхзүйн баримт бичгүүдийг шинэчилсэн байна. Холбогдох талуудад танилцуулж, хэлэлцүүлсэн байна.	Х, Г
	7.Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй эрхзүйн акт, бодлогын нийцэлд дүн шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах ажлыг холбогдох нэгж, албан хаагчтай хамтран зохион байгуулах;	Холбогдох нэгж, албан хаагчтай хамтран ажилласан байна.	Х, Г
	8.Хууль, дүрэм журмын хэрэгжилт, зөрчлийн нэгдсэн бүртгэл хөтлөх, тэдгээрийг арилгах зөвлөмж, гарын авлага боловсруулах.	Холбогдох гарын авлага эмхэтгэлийг гаргасан байна.	Г, Х, Т
	1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дүгнүүлэх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх;	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Х, Г
	2.Яамны удирдлага, бусад нэгжээс шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл	Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна.	Г



3 дугаар зорилтын хүрээнд	судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх;		
	3.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг "Яамны хөтлөх хэргийн жагсаалт"-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах;	Архив албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна.	Г
	4.Төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх;	Хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн байна.	Т, Г, Х
	5.Газрын дотоод ажлыг хариуцан, тухайд нь төлөвлөлт, тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн бэлтгэх ажлыг хариуцан зохион байгуулах.	Тайлан, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	- Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	- Боловсрол /0111/, багш, мэргэжлийн /0114/, эрх зүй/042/, менежмент /0413/, эдийн засаг /0311/	
Мэргэшил	- Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх	
Туршлага	- Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх - Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр эсхүл тухайн салбарт 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - ерөнхий болон дээд боловсрол, харьяа байгууллагын хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ аливаа асуудлыг оношлох, шалтгааныг тодорхойлох, задлан шинжлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг оновчтой тайлагнах; - хяналт шинжилгээ үнэлгээ хийх, харьцуулсан судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - баримт бичигт дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх; - мэдээлэл цуглуулах, нэгтгэн боловсруулах; - бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - эрхлэх асуудалд хамаарах ажил үүргийг хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн чанартай гүйцэтгэх;



		<ul style="list-style-type: none"> - бодит баримт нотолгоонд тулгуурлан асуудлын шийдлийн хувилбарыг боловсруулж түүний шалтгаан, үр дагаврыг тодорхойлон нэгжийн удирдлагад танилцуулах; - салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар хууль тогтоомж болон нийтийн эрх ашигт нийцсэн, оновчтой, үр дүнтэй санал боловсруулах; - эрхлэх асуудлын хүрээнд аливаа асуудлыг хууль болон төрийн албаны зарчимд нийцүүлэн ашиг сонирхлыг зөрчлөөс ангид шийдвэрлэх; - шийдлийн хувилбар, санал, мэргэшлийн зөвлөмж, зөвлөгөөний үнэн зөв байдал, үр дагаврыг хариуцах; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа эерэг мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч нээлттэй харилцааг бий болгох; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах; мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах; - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - харилцааны соёлыг эрхэмлэн, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - жендэрийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах; - албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах; - харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх; - төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект



-байхгүй	- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс; - Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан; - Иргэн, хуулийн этгээд мэргэжлийн байгууллага.
----------	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

АЖЛЫН ХЭСТГИЙН АХЛАГЧ

..... /Б.ГАНТУЛГА/
(Гарын үсэг)

2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 22 03 30

Дугаар: 168

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Шийдвэрийн огноо: 2022. 04. 04

Дугаар: 5/34

(тамга/ тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

.....
(Гарын үсэг)

/Л.ЦЭДЭВСҮРЭН/

(Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2022 оны 04 дугаар сарын 04-ны өдөр

